

АРДЫН НАМЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА
“МОНГОЛЫН ҮНЭН” СОНИНЫ ЗАРИМ НИЙТЛЭЛД ХИЙСЭН
АЖИГЛАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Т.Баасансүрэн*

*УБЭИС-ийн Сэтгүүл зүй, олон улс судлалын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph,D), профессор

Түлхүүр үгс: Ардын намын гишүүд, “Монголын үнэн” сонин, бичлэгийн утга агуулга, арга хэлбэр, дүр дүрслэл, намч марксист хэвлэл, нууц ухуулах хуудас

Д.Сүхбаатар, Х.Чойбалсан зэрэг Монгол Ардын Намыг төлөөлсөн ардын хувьсгалчид 1920 оны 8 дугаар сард Орос улсад тусламж гуйж очихдоо туршлага судлах явдлыг эрхэмлэн чухалчилж байсан нь ихээхэн сонирхол татдаг. Тэдний нэг гол зорилго нь хувьсгалыг зэвсэгт тэмцлийн замаар ялуулах, үүний тулд хувьсгалт хэвлэлийг үүсгэн байгуулахыг зорьж байсан нь ОК/б/Н, Коминтерний алс дорнодын Хорооны нөхдийн анхаарлыг татаж, сэтгэлд нь нийцжээ.

Монголын хувьсгалчид айлын талаас хэмжээ багатай ухуулга хуудас, уриалга зэргийг хэвлэж болох жижигхэн чулуун барын хэвлэх үйлдвэр хэрэгтэй байна гэж хүсээд “Намын ойрын зорилтын талаарх санал”-даа “Нэгд олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” гэж зайлшгүй хэрэг-

цээгээ тайлбарлажээ. Оросод байх хугацаандаа Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Лосол, Д.Бодоо нарын зэрэг хувьсгалчид ОК/б/Н, Коминтерний холбогдох нөхөдтэй, мөн тэнд ажиллаж байсан өөр улс орны зарим төлөөлөгчидтэй уулзалдаж хэвлэх үйлдвэр, хэвлэлийн үйл ажиллагааны туршлага судалж байсан мэдээ мэдээлэл түүхэнд бичигдэж үлдсэн байна.

1917 оны Октябрийн хувьсгалын үзэл санааг даян дэлхийд түгээн тархааж “Даян дэлхийн зөвлөлт улс”-ыг байгуулж өөрсдийн нөлөөллийн бүсээ болж өгвөл таван тивд, тэргүүн ээлжинд Алс Дорнодод /Монгол, Хятад, Солонгос гэх зэрэг/ өргөжүүлэн тэлэхийг мөрөөдөж бүхий л бодлого, үйл ажиллагаагаа энэ чиглэлээр идэвхжүүлж байсан ОК/б/Н, Коминтерний нөхдөд Х.Чойбалсан, Д.Лосол, Д.Сүхбаатар нарын Монголын хувьсгалчдаас тавьсан дээрх санал сэтгэлд нь яв цав нийцсэн бололтой санагддаг. Тэд 1917 оны Октябрийн социалист их хувьсгалыг мандуулсан өөрсдийн үйл ажиллагааны туршлагаасаа

Монголын хувьсгалчидтай харамгүй хуваалцаж, тэргүүн ээлжинд аливаа хувьсгалыг мандуулж ялалтад хүргэхэд ухуулга сурталчилгаа амин чухал болохыг тэмдэглэж Ильич Лениний “Искра” сонины жишээгээр, ОК/б/Н-ын төв индэр “Правда” сонины туршлагаас ярьж танилцуулсан нь бүгдэд ойлгомжтой. Өөрөөр хэлбэл хувьсгалт хэвлэлийн ухуулан таниулж, үзэл санааг сурталчлан түгээх, түүнийгээ практикт ажил хэрэг болгож зохион байгуулах хосгүй чухал чанартайг Монголын хувьсгалчдад ойлгуулахыг чармайжээ гэж хэлж болохоор байгаа юм. Октябрийн социалист хувьсгалыг мандуулахад ОК/б/Н-ын сонин хэвлэл, ялангуяа “Искра”, “Правда” зэрэг хэвлэл онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг бөгөөд тэр үеийн оросын хувьсгалчид хувьсгалын үйл хэргийг сурталчилгааны сонингүйгээр төсөөлөх ч аргагүй болтлоо тийм өндөр итгэл үнэмшилтэй болчихсон байсан цаг үе юм. Хувьсгалт тэмцлийн цагаан толгойн А үсэг нь “Искра” сонины туулсан замнал гэж үзэж байсан нь бодит үнэн билээ. Тэрийг ч мэдэж гадарлаж байсан учраас Монголын хувьсгалчид тусламжийн саналдаа олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана гэж онцлоод хэмжээ багатай ухуулах хуудас, уриалга зэргийг хэвлэж болох жижигхэн чулуун барын хэвлэх үйлдвэр зайлшгүй хэрэгтэй байна. Дараа нь мөн эндээ, Эрхүүд монгол хэл дээр зохиол хэвлэх ажлыг зохион байгуулах зайлшгүй шаардлагатай гэж бичиж байсан байна.

1920 оны 8 дугаар сард Оросод очсон Монголын хувьсгалчдын хувьд тусламж дэмжлэг авах нь

тэргүүн зэргийн зорилт байсан ч түүнээс дутахгүй ач холбогдолтой зүйл бол Оросын хувьсгалчдын үйл ажиллагааны туршлага судлах, 1917 оны Оросын хувьсгалын ялалтын арга тактикаас суралцах явдал байсан гэдэгт би хувьдаа огтхон ч эргэлзэхгүй байна. Оросод байх хугацаандаа Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарын хувьсгалчид ОК/б/Н-ын болоод Коминтерний Эрхүү хот дахь салбарын удирдагчидтай төдийгүй тэнд ажиллаж байсан Чехийн хувьсгалч үзэлтэй сэтгүүлч Ярослав Гашектай хүртэл уулзалдаж байсан нь ингэж хэлэх үндэслэл болж байгаа юм. “Эрэлхэг цэрэг Швейкийн адал явдал” зохиолоороо алдаршсан Ярослав Гашек Эрхүүд байхдаа герман, унгар, буриад хэлээр хэвлэгддэг гурван ч сонины редактороор тохоон томилогдож нийтлэл бичдэг байсан тухайгаа үзэг нэгт Чехийн сэтгүүлч Ярослав Салат-Петрликт бичсэн захидалдаа дурджээ.

Коминтерний ажилтан И.А.Сороковиков нь Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нар Эрхүүд Ярослав Гашектай нэг биш удаа уулзаж сонин хэвлэл барлаж гаргах ажлыг нарийвчлан үзэж, хэвлэл нийтлэлийн үйл ажиллагааны онцлогийг сонирхож байсныг, мөн түүнчлэн Оросын судлаач Б.С.Санжиев Эрхүү губернийн комсомолын хорооны дарга Е.Кузин цаас авахаар 5-р армийн улс төрийн хэлтсийн орлогч Ярослав Гашекийн ажил дээр 1920 онд очихдоо Х.Чойбалсантай таарсан гэдгийг тэмдэглээд “5-р армийн улс төрийн хэлтэст 1920 оны 9 дүгээр сард Х.Чойбалсанг Ярослав Гашек хүлээн авчээ... Гашек юуны тухай Чойбалсантай ярилцсан нь тов

тодорхой” (Б.Галаарид, 2021) гэж бичиж үлдээсэн байдаг аж.

Эдгээрээс харахад Монголын хувьсгалчид тухайн цаг үед сонин хэвлэлийн үйл ажиллагааны туршлага судалж байсан нь аяндаа ойлгогдож байгаа юм. Өөрөөр хэлбэл Монголд зохион байгуулж хэрэгжүүлэх ухуулга сурталчилгаа, сонин хэвлэлийн үйл ажиллагааны чиглэл дээр хоёр талын санал бодол нийлж нэгдэж байжээ, зөрчилдөж зөрөлдөх зүйл төдийлөн байсангүй гэж бодогдохоор байгаа юм. Үүнд эргэлзээж тээнэгэлзэх зүйл бараг үгүй буй заа.

Доктор Лодонгийн Түдэв 2000 онд “Үнэн: наян жилийн намтрын товъёог /1920-1996/” гэдэг ном хэвлүүлжээ. Эхний хуудсан дээр нь товъёог үйлдсэн доктор Лодонгийн Түдэв гэж бичээстэй байгаа. /Сүүлд Ж.Пүрэв нэмэгдэж номыг гүйцээхэд нь гар бие оролцжээ/.

Зохиогч “Монголын үнэн” буюу “Үнэн” сонины түүхтэй холбоотой чухал эх сурвалжийн нэг болсон уг номондоо нэгд, “Монголын үнэн” сонины 1920-1921 оны 6 дугаар, хоёрт, “Уриа” сонины 1921-1922 оны 21 дугаар, гуравт, “Нийслэлийн шинэ сонин”-ы 1923-1924 оны 22 дугаар, дөрөвт, “Ардын эрх” сонины 1924-1925 оны 50 дугаар, тавд, “Үнэн” сонины 1925-2000 оны хоорондын бүх дугаарын талаарх товч товъёог мэдээллийг багтаажээ.

1920 оны XI сарын 10-нд анхных нь дугаар хэвлэгдсэн “Монголын үнэн” сонины тухай энэхүү товч мэдээлэлд:

Санаачлагч нь: 1919 оноос эхлэн Монголын ардын хувьсгалчдаас бичиж тарааж байсан нууц ухуулах

хуудас бичигчдийн нэг Дамдины Сүхбаатар,

Эрхлэн гаргагч нь: Монгол Ардын Нам, Коминтерний Алс дорнодын Хорооны Монгол, Түвдийн хэлтэс,

Ажилтан нь:

1. Монгол Ардын Намаас томилогдсон зохиолч Сономбалжирын Буяннэмэх /Шүүтгэн нягтлагч/
2. Д.Сүхбаатар /Эх зохиогч/
3. Х.Чойбалсан /Эх зохиогч/
4. С.Данзан /Эх зохиогч/
5. Д.Лосол /Эх зохиогч/
6. Д.Ишдорж /Зохиогч, утга зохиолын ажилтан/
7. Ч.Пүрэв /Үсэг хянагч/
8. Ярослав Хашек /Чехийн зохиолч, Буриадын “Үүр” сонины эрхлэгч/
9. Б.Шумяцкий /Оросын хувьсгалч, Коминтерний зүгээс Монголын хувьсгалчдад туслаж холбоо баригч/
10. С.Борисов /Оросын хувьсгалч, Коминтерний ажилтан/
11. Э.Ринчино /Оросын хувьсгалч, Коминтерний ажилтан/ (Түдэв, 2000)

гэж “Монголын үнэн” сониныг үүсгэж хэвлэн гаргахад биечлэн оролцогчдыг нэрлэн дурджээ. “Үнэн: наян жилийн намтрын товъёог /1920-1996/” бүтээлийг туурвигч доктор Лодонгийн Түдэв “Монголын үнэн” сонины талаар өөрийн үйлдсэн тайлбартаа “Энэ сонин 1919 оны 10 дугаар сараас 1921 оны 7 дугаар сар хүртэл гарч байсан нууц ухуулах хуудасны шууд үргэлжлэл болжээ” (Түдэв, 2000) гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл доктор Л.Түдэв 1921 оны хувьсгалт тэмцэл 1919 онд ухуулах хуудсаар эхлээд 1920 онд “Монголын үнэн” сонин болж өргөжсөн гэж үзжээ. Үүнийг би бодит үнэнд харьцан-

гүй дөхөж очсон үнэн баримт мөн болов уу гэж бодож байна.

Сүүлд 2004 онд хэвлэгдсэн /Хорлоогийн Цэвлээгийн эрхэлсэн/ “Үнэн 20000, 84 дэх жилдээ” номын нүүрэн дээр Монголын өдөр тутмын сонин “Үнэн”, санаачлагч нь Д.Сүхбаатар гэж мөн нэгэн адил тодотгоод /Сүхбаатарын 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгийн зураг бүхий/ дотор нь “Сонины эрхлэгчид” гэсэн гарчигт “Монголын үнэн” сонины эрхлэгчээр ажиллаж ирсэн 20 хүний товч намтрыг оруулжээ. Энэхүү бичлэгийн нэгдүгээрт “Сономбалжирын Буяннэмэх нь Эрхүү хотноо Коминтерний Алс дорнодын хэлтэст Ардын намын төлөөлөгчөөр томилогдож “Монголын үнэн” сониныг гаргалцаж байсан хариуцлагатай редактор /нарийн бичгийн дарга/ юм. Тэгэхээр түүхэн уламжлалыг дагуулан байцааваас С.Буяннэмэх бол “Үнэн” сонины анхны эрхлэгч мөн гэж үзэх үндэстэй байна” (Цэвлээ, 2004) гээд Л.Түдэв, Жа.Пүрэв нарын үйлдсэн “Үнэн: Наян жилийн намтрын товъёог дахь дээр дурдсан тэмдэглэгээг бүрэн эхээр нь оруулж, залгуулаад уг сонины эрхлэгчээр нь ажиллаж ирсэн С.Буяннэмэх нарын 20 хүний товч намтрыг дагалдуулжээ.

Хорлоогийн Цэвлээгийн энэ саналыг би зөв зүйтэй, оновчтой тодорхойлолт гэж үзээд талархан дэмжиж байгаа болно. Сономбалжирын Буяннэмэхийг сонин хэвлэлийн ажлын түүхэн уламжлалын үүднээс авч үзэх юм бол “Монголын үнэн” сонины анхны эрхлэгч гэж үзэх бүрэн үндэстэй байгаа юм. Доктор Лодонгийн Түдэв “Монголын үнэн” сониныг үүсгэгч нь Монгол Ардын

Нам ба Коминтерний Алс дорнодын хорооны Монгол, Түвдийн хэлтэс гэж үзээд чухам энэхүү түүхэн үнэнийг иш үндэс болгож “Монголын үнэн” сониныг санаачлагч нь Монгол Ардын Намыг үндэслэгч хийгээд 1919 оноос ардын хувьсгалчдаас бичиж тарааж байсан нууц ухуулах хуудсыг бичиж зохиогчдын нэг Дамдины Сүхбаатар мөн гэж үзсэн бололтой санагддаг. Ингэж үзэх, ингэж хэлэх үндэслэл байхгүй биш байгаа бөгөөд “Монголын үнэн” сониныг санаачлагч нь Д.Сүхбаатар мөн гэхэд гайхаж эргэлзэх, учиргүй маргаж дургүйцэн мэтгэлцэх хүн нэг их олон гарахгүй явж ирсэн буй заа гэж бодном. Тэр бол “Монголын үнэн” сониныг зөвхөн бэлтгэх, түгээх ажилд оролцож, айлын талтай хамтран ажилласнаар өөрийгөө хараахан хязгаарлаагүй нь олон баримтаас харагдаж байгаа юм.

“Үнэн” сонин бол зүсээ биш сэтгэлгээгээ харах толь” хэмээх ярилцлагадаа Л.Түдэв “Монгол Ардын Нам өөрийгөө байгуулж, нэр, хөтөлбөрөө зарлахаас өмнө 1920 онд “Үнэн” сонин төрснөөрөө намаасаа ч ах сонин. Намаа төрүүлж, эх барьж авахын тулд ч “Монголын үнэн” сониныг намын ууган зүтгэлтнүүд гаргаж, Д.Сүхбаатар, Д.Бодоогоос эхлээд өөрсдөө эхлэн бичигчид болсон нь учиртай” гэжээ. /“Монголын үнэн” сонины 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн № 042 /24573/ -ыг харна уу/.

“Монголын үнэн” сонины 103 жилийн ойг тохиолдуулан тус сонины газар, МАН-ын дэргэдэх Стратеги академи уншигчиддаа нэгэн содон бэлэг барьсан нь “Монголын үнэн”

/1920-1921 онд хэвлэгдсэн анхны зургаан дугаарын эмхэтгэл/ байв. Энэхүү түүхт ойн өдрийн “Монголын үнэн” сонинд: “Хүрээний хувьсгалчид нууц бичиг захидал, ухуулга хуудас энд тэнд нааж байснаа 1920 онд Эрхүүд “Монголын үнэн” нэртэй сонин хэвлүүлэн Нийслэл Хүрээнд оруулж ирсэн түүхтэй. Одоогоос яг 103 жилийн өмнө Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Лосол тэргүүтэй хувьсгалчид санаачилж, Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг С.Буяннэмэх тэргүүтэй бичгийн мэргэд анхны мэдээ, мэдээллийг нь бэлтгэж, тухайн үеийн сэхээтнүүдийн төлөөлөл Д.Ишдорж, Ч.Пүрэв нар ариутган шүүж, Алс Дорнодын Коминтерний нарийн бичгийн дарга нарын газрын дарга Б.З.Шумяцкий, Коминтерний төлөөлөгч С.Борисов, Э.Ринчино нарын оролцоотойгоор гарч байсан энэ сонин 100 гаруй жил насалж, Монгол Улсын түүхийн салшгүй нэг хэсэг болно гэж тэр цагт хэн ч төсөөлөөгүй нь лавтай” гэж “Монголын үнэн” сонины ерөнхий эрхлэгч Б.Цоожчулуунцэцэг “Монголын үнэн” 104 дэх жилийн түүхээ бичиж эхэллээ” нэртэй нийтлэлдээ цохон тэмдэглэсэн нь дээрх бүх агуулгын хураангуйлсан илэрхийлэл гэж хэлж болохоор байгаа юм. /“Монголын үнэн” сонины 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн № 042 /24573/-ийг үзнэ үү/. Эдүгээ буюу 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс энэ сонины 105 дахь жилийн түүх нь бичигдэж эхэлчхээд байна.

Ийм жишээ баримтыг хэдэн арваар хэлж ишлэж нэрлэж болно. Тэр бүгдийг түүвэрлэбэл уншигч таны үнэт цагийг хий дэмий үрж

болзошгүйгээс эмээж энэ удаад түр түдгэлзэв. Эдгээр нь 1921 оны ардын хувьсгалыг гардаж хэрэгжүүлсэн Монгол Ардын Нам нь /Гадаад талдаа олон улсын харилцаанд болохоор Монгол Ардын Хувьсгалт Нам гэж тухайн цаг үеийн улс төрийн нөхцөл байдал, дэлхий дахины хувьсгалт хөдөлгөөний чиг хандлагад нийцүүлэн нэрлэж байхаар хувьсгалчид дотроо ярьж тохиролцсон байдаг. Т.Б/ ухуулга таниулга, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ихээхэн анхаарал тавьж, сонин хэвлэлийг өөрийн бодлого, үйл ажиллагааг сурталчлах, улс нийгмийг хөгжүүлэх талаарх намын стратеги тактикийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд юугаар ч сольшгүй хүчтэй зэвсэг мөн гэж ойлгон ашиглаж, зүйл бүрээр хөхиүлэн дэмжиж ирснийг харуулж байна. Түүний хамгийн тод илрэл нь 1921 оны хувьсгалчдын нууц ухуулах хуудас, уриалга таниулга хийгээд тэдний үзэл бодол, МАН-ын хувьсгалт тэмцлийн стратеги тактикийг ил тодоор илэрхийлж олон түмэнд хүргэж сурталчилсан “Монголын үнэн” сонин юм гэж бүрэн итгэлтэй хэлж болохоор байгаа юм.

Үүнийг үнэмшилтэйгээр батлах хамгийн тод баримтууд гэвэл “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” болох “Монголын үнэн” сонины 6 дугаарын нийтлэлүүд даруй мөн болно. Бүгдийг биш ч ганц нэгээс нь нэр зааж утга агуулга хийгээд хэл найруулга зэргээр нь хөөн тодотгож хэнд илүүтэй хамаатай, бас хамааралтай болохыг задлан шинжлэх гэж оролдоё.

“Монголын үнэн” сонины 1920 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн анхны дугаарт “Манай зорилго”, “Монгол Улсын боловсролын мандах явдал тус”, 1920 оны 12 дугаар сарын 1-ний хоёр дахь дугаарт “Монгол Улсад ямар засаг хэрэгтэй вэ?”, 1920 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн гурав дахь дугаарт “Монголын шинэ ардын засаг байгуулах үндсэн журам”, “Монгол Улс сэрэмжилтүгэй”, 1921 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 4 дэх дугаарт “Монгол Улсын энэ цагийн байдал ба ардын намын бүтээх зүйлүүд тус”, “Монгол Улсын шинэ, ард олны эрхэт, төвийн ба нутгийн янз төлвийн тус”, 1921 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн тав дахь дугаарт “Монгол ардын намаас гадаад Монголын түмэнд тунхаглан зарлах бичиг”, “Монгол Улсын ардын эрхэт засаг тогтосны тус”, 1921 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн зургаа дахь дугаарт “Рибиний байдал ба Монголын хэрэг”, “Гадаад Монголын хошууд ба харуулуудын олон түмний болон ард цэргүүд хийгээд ардын намын хүн нарын олноо өргөгдсөний 11 оны 2 дугаар сарын 25-нд болсон хуралдаанаар Монгол Ардын Засгийн Хэргийг бүгд түр захиран шийтгэх газар сонгож баталсан бичиг”, “Ардын намын олон сэтгэлгээ хамтатгах ах дүү нар танаа сонордуулах нь”, “Монгол Ардын Намын Төв хорооны бичиг. Оросын цагаан намын Барон Унгерний цэргийн дотор бүхий олон монгол цэргийн ах дүү нарт сонсгох нь” зэрэг 1921 оны ардын хувьсгал, зэвсэгт тэмцлийн үндсэн гол зорилго, стратеги тактик, үр дүнд нь байгуулагдах Ардын засгийн газрын бүтэц хэлбэр, үйл ажиллагааны ямар зарчим барим-

талвал зохилтойг зааж тодорхойлсон удирдамж чиглэлүүд хэвлэгджээ. Монголд ямар засаг төр хэрэгтэйг ингэж ойлгуулан таниулахын хамт Монгол Улс юунаас яаж сэрэмжлэх ёстойг ухуулж, тухайн цаг үеийн гадаад, дотоод нөхцөл байдалд Монгол Ардын Намаас юу юуг чухалчлан хийж бүтээх шаардлагатайг, үүний тулд ард түмний засаглалын хэлбэр төвд болоод орон нутагт ямар байдалтай байвал зохистойг тайлбарлаж, дөнгөж сая байгуулагдсан Ардын шинэ засгийн газраас баталсан бичиг баримтууд болоод Ардын намын бодлогыг өргөн олон түмэнд, түүний дотор Барон унгерний цэрэгт алба хааж буй монгол ах дүү нартаа хүртэл учрыг ухуулан сонордуулж байсан байна.

Дээр нэр дурьдсан эдгээр өгүүлэл нь “Монголын үнэн” сонины удирдамжийн шинж чанартай тэргүүн өгүүллүүд ба Монгол Ардын Намын тэмцлийн программ, Ардын шинэ засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, зорилгыг илэрхийлсэн гол бичиг баримтууд юм. Үүнээс гадна нэр бүхий 6 дугаарт “Гадаад Монголын ардын намын төлөөлөгчид нараар”, “Да хүрээний мэдээ”, “Монгол ардын цэргийн байлдааны ажил” зэрэг тухайн цаг үед Монгол оронд болж байсан үйл явдлын талаарх мэдээ мэдээллүүд бас бий. Товчдоо “Монголын үнэн” сонины нийтлэлүүд бүхэлдээ Монголд зориулагдаж эрх чөлөө, тусгаар тогтнолоо хар шар, эр эмгүй бүгдээрээ нийлж нэгдэж хамтын хүчээр олж авах, өөрөөр хэлбэл зэвсэгт тэмцэл өрнүүлэн харийн түрэмгийлэгчдийг эх нутгаасаа хөөн зайлуулах сэдэвтэй байгаа юм. Эдгээр бичлэг

нь үнэхээр л олны сэтгэлийг хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг мөн болой.

Мэдээж “Монголын үнэн” сонины 6 дугаарын нийтлэлүүдийн нилээд хэсгийг гадаад мэдээ, олон улсын байдал, түүний дотор Зөвлөлт Орос Улс, Октябрийн социалист хувьсгалын үзэл санаа ялан мандаж байгаа тухай өгүүлсэн өгүүлэмжүүд эзэлж байгаа. Мөн л хүмүүсийн уншиж мэдэхийг хүсэмжилсэн элдэв зүйлийн бодлогот мэдээ мэдээллүүд.

Эдгээрт хийсэн агуулгын судалгаа, “Монголын үнэн” сонины 6 дугаарын нийтлэлийн бодлогод хийсэн ажиглалт шинжлэлээ миний бие доктор Д.Дашийн оршил бичиж 1971 онд хэвлүүлсэн “Монголын үнэн сонин” /сонинд нийтлэгдсэн өгүүлэл, мэдээний эмхэтгэл/ номонд орсон материалуудад тулгуурлаж 2009 онд хэвлүүлсэн “1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил” (“Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь”, 2009) номондоо “Монголын үнэн” сонин нийгмийг шинэчлэх хувьсгалт тэмцэлд уриалан дуудсан нь” хэмээх нэгдүгээр бүлэгт дэлгэрэнгүйгээр уншигчдад нэгэнт хүргэж танилцуулсан тул энд давтан нуршсангүй.

Сүүлд буюу 2023 онд МАН-ын төв хэвлэл “Монголын үнэн” сонины газар, тус намын Стратеги академис хамтран хэвлүүлсэн “Монголын үнэн” /1920-1921 онд хэвлэгдсэн анхны зургаан дугаарын эмхэтгэл/-ийг үзвэл 1971 оны анхны хэвлэлд орхигдсон зарим үг, өгүүлбэрийг нөхөн оруулж, ташаарсныг залруулж, мөн зарим дугаарын зураасан зургуудыг хэвлэжээ. Энэ бол жижиг

гэлтгүй хэрэгтэй чухал нөхөлбөр болсон байна. Жишээ нь “Монголын үнэн” сонины 1920 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 3 дахь дугаарын “Монголын шинэ ардын засаг байгуулах үндсэн журам” өгүүлэлд *“Монгол Улс нь хэдэн зуун жилийн дотор үе залгамжлан суух ёсны засагтай агснаар Чингис хааны угсаа болох авч мугуй, муу хүн нарт эзлэгдэж, тэд нар нь Их Монгол улс төрийг сарниулж Монголын олон түмнийг Хятад, Манж нар Орос болон Төвд нарын боол болгон авахуулж урьдын аугаа хүчин төгөлдөр их Монгол Улсыг дэлхий дахины хамгийн дорд ядуу үгээгүй мунхаг харанхуй улс болгожээ. Их мэргэн Чингис хаан нь ард түмний ба улс төрийн хэрэг тусад үе залгамжлах засаг болбоос зүй үгүй харштай гэмтэйг сайтар мэдэх тул, өөрийн гэрээс үг болгон захисан нь хойшид дараалан суух засгуудыг Монгол үндэстэй олон түмний ба цэргүүдийн их хуралдаанаар сонгон тавьж байгаарагтун /байгтун/ хэмээсний ёсоор анхан дээр Монголын хаад Өгэдэй Гүег тэргүүтэн тэрхүү хуралдаанаар сонгогдож тавигдсан бөгөөтөл /байтал/ хойш Чингисийн мэргэн зарлиг умартагдаж, Монгол Улс төрийг Тогоонтөмөр хэмээгч мэтийн мугуй хүн нар эзэлж агсан билээ”* гэснийг нөхөн оруулсан байна. Тухайн цаг үед буюу 1971 онд “Монголын үнэн” сонины 6 дугаарын нийтлэлүүдийг нэгтгэж эмхэтгэсэн товхимолд Чингисийг нэр зааж сургаал айлдварыг нь сануулан дурдах нь үндсэрхэг үзлийг дэвэргэж орос ах нарын дургуйцлийг төрүүлнэ гэж болгоомжлон засгийн эрх баригч

намын зүгээс үүнийг хасаж байсан түүхтэй гэнэ.

Мөн “Монголын үнэн” сонины 1921 оны 4-р сарын 19-ний өдрийн 6 дахь дугаарын “Монгол ардын намын төв хорооны бичиг. Оросын цагаан намын барон унгерний цэргийн дотор бүхий олон монгол цэргийн ах дүү нарт сонсгох нь” хэмээх мэдээлэл 1971 оны “Монголын үнэн” /сонинд нийтлэгдсэн өгүүлэл, мэдээний эмхэтгэл/ номонд “Үүнд хуучин бичигт үзвээс, манай Монголын эртний өвгөд... асар сүр, яруу алдартай агсан ажгуу” гэж байгааг 2023 оны “Монголын үнэн” /1920-1921 онд хэвлэгдсэн анхны зургаан дугаарын эмхэтгэл/-д “Үүнд хуучин бичигт үзвээс, манай Монголын эртний өвгөд эзэн хаан Чингис ба Хубилай сэцэн хааны үед дэлхий дээр манай Монголын адил зориг хүчтэй байсангүй бөгөөд, ижилгүй утга хүчтэй асар сүр, яруу алдартай агсан ажгуу” гэх зэргээр мөн нэмж нөхөн гүйцээжээ. Тэр цаг үед манай Монголын эрт дээр үеэс уламжлагдан ирсэн зан заншил, ёс суртахууныг харийн улс орнууд доромжлон дарлах зэрэг явдал огт байсангүй гэж тодотгожээ.

Нэр бүхий дээрх өгүүлүүдэд Монгол бол хэдэн зуун жилийн турш туурга тусгаар их гүрэн явж ирсэн алдарт түүхтэй. Их мэргэн Чингис хааныхаа зарлиг захиасыг умартаж хоорондоо эвдрэлцэн Тогоонтөмөр мэт муу хүмүүст төрийн жолоог атгуулснаас Их Монгол Улсын төрийг сарниулж Хятад, Манж хийгээд Орос болон Төвд нарын боол болцгоосон. Монгол улсын эртний өвгөд эзэн хаан Чингис, Хубилай сэцэн хаан шиг

хүчтэй чадалтай, зоригтой золбоотой нь дэлхийд байсангүй. Их Монгол Улс ижилгүй хүчтэй, асар өндөр сүр хүчтэй, яруу алдарт том гүрэн байлаа гэсэн байна.

“Монголын үнэн” сонины 1920 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн анхны дугаарын магнай дээр *“Ард олны чөлөө эрх дэлхий дахинаа наран мэт бадран, Монгол Улсын язгуур үндэс эрдэм соёл нь дэлгэрэн мандах болтугай”*, 1920 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Монголын үнэн” сонины № 3-ын тэргүүн нүүрийн оройд *“Хятадын эзэрхэг харгисууд ба тэдний лүгээ өнгө мөнгөний тул нөхөрлөн бялдуучлагчдад битгий итгээгтүн. Тэднээр улс төрөө засуулан боловсорсугай хэмээвээс мал сүргээ чоноор мануулан өсгөсүгэй хэмээсэнтэй адил бишүү”*, 1921 оны 3 дугаар сарын 5-ны “Монголын үнэн” сонины манлайд болохоор *“Эзэрхэг түрэмгий Рибиний зарц, Оросын харгис дээрэмчин, Унгерн ба түүн лүгээ мунхаг охор бодолт зальхай нарын урхи зангын адил арга мэх дор олон монголчууд битгий хууртагтун”* хэмээн тус тус уриалан дуудсан байна. Энэ нь сонины тухайн дугаарын нийтлэлүүдийн гол агуулга, үндсэн утга санааг шууд илэрхийлж байгаа юм. “Монголын үнэн” сониныг үүсгэн хэвлүүлсний чухам утга учир үүнд оршино гэдгийг давтан хэлье. “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” хэмээх нэр томьёо нь эдгээр уриалгын утга агуулгаар бүрэн гүйцэд тайлагдан уншигдаж байгаа болно.

Ийм үг өгүүлбэр хэний амнаас унах вэ, мэдээж монголчуудын амнаас л унана шүү дээ. Хэн ингэж

бичих вэ, монголчууд л ингэж бичнэ. Орос хүн бичихгүй, орос хүн хэзээ ч ингэж хэлэхгүй. Тэдгээрийг уншиж шинжиж суухад “Монголын үнэн”

сонины нийтлэлүүд “Би монгол, монгол, орос хүүхэд биш, монгол хүүхэд, “Монголын үнэн” шүү гэж хашгирч байх шиг санагдсаныг нуугаад яахав. Үүнийг би доктор Б.Галааридын “Ер нь “Монголын үнэн” сонинтой холбогдол бүхий орос хэл дээрх баримтуудад Монгольская газета, “Монголын үнэн” /“Монгольская правда”/ гэж бичсэн болохоос “Газета Монголии” гэж нэг ч удаа бичээгүй нь энэ сонин Монголын сонин биш гэдгийг нотлох нотолгоо юм. Оросоор “Монгольская газета” гэвэл “Монгол сонин”, “Газета Монголии” гэвэл “Монголын сонин” гэсэн утга илэрхийлнэ гэдгийг энэ олон жилийн хугацаанд судлаачид

анзаарч ач холбогдол өгөөгүй нь гайхшрал төрүүлж байна” (Б.Галаарид, 2021) гэсэн эсэргүүцэл, түүнчлэн “Ер нь “Монголын үнэн” сонины үндсэн өгүүллүүдийг орос

хэлээр бичээд монгол руу буулгасан байх магадлалтайг зарим үг нэршлийг оросоор нь хэрэглэсэн явдал харуулдаг” (Б.Галаарид, 2021) гэсэн

гаргалгаатай холбогдуулан зориуд хариу болгон хэлж байгаа юм. “Монгольская газета”, “Газета Монголии” буюу эсвэл “Монголын үнэн” ба “Монгольская правда” хэмээх үгийн орос, монгол утга илэрхийллийн харьцууллын нарийн ширийнд хэл шинжлэлийн ухааны эрдэмтэд-орос хэлний дагнасан мэргэжилтэн шиг шурган орж судсыг нь барьж чаддаггүй юмаа гэхэд “Монголын үнэн” сонины монгол үг хэллэг, найруулга зүй хийгээд утга агуулгын бүтэц, илэрхийлэл, зохион байгуулалтын зохицолт байдалд монгол хүний хувьд ажиглаж шинжээд харь хэлнээс халтартуулж махчилсан хадмал хараахан биш л харагдаад байна

даа гэж огт аймшиггүйгээр цор цор хийх гээд байгаа юм.

Хамгийн яруу тодорхой баримт нь дээр дурьдсан хоёр өгүүллийн үг өгүүлбэрүүд, “Монголын

«

Тэдгээрийг уншиж шинжиж суухад “Монголын үнэн” сонины нийтлэлүүд “Би монгол, монгол, орос хүүхэд биш, монгол хүүхэд, “Монголын үнэн” шүү гэж хашгирч байх шиг санагдсаныг нуугаад яахав. Үүнийг би доктор Б.Галааридын “Ер нь “Монголын үнэн” сонинтой холбогдол бүхий орос хэл дээрх баримтуудад Монгольская газета, “Монголын үнэн” /“Монгольская правда”/ гэж бичсэн болохоос “Газета Монголии” гэж нэг ч удаа бичээгүй нь энэ сонин Монголын сонин биш гэдгийг нотлох нотолгоо юм. ... түүнчлэн “Ер нь “Монголын үнэн” сонины үндсэн өгүүллүүдийг орос хэлээр бичээд монгол руу буулгасан байх магадлалтайг зарим үг нэршлийг оросоор нь хэрэглэсэн явдал харуулдаг” гэсэн гаргалгаатай холбогдуулан зориуд хариу болгон хэлж байгаа юм

»

үнэн” сонины магнай дээрх уриа
лоозон гэдгийг дахин хэлье.

Залхууралгүйгээр ахиад цөөн
жишээг нэмж толилуулья.
Жишээ нь “Хуучин байдал ёс
нь нийтэд тэгш бус шударгагүй хилс
хэлтгий бөгөөд олон улс нарын төр
засгийн мэдэл нь хөрөнгийн эрхэнд
бишрэгч харгис ноёлог баячуудын
гарт байснаар зарим хүн нар өөр
лүгээ адил олон түмнийг боолчлон
дарлаж, элдэв ядрал зовлонд
учруулж гагцхүү өөрсдийн ашиг тусыг
бүтээж ба тэрчлэн нэгэн язгуурын
улс, нөгөө язгуурын бага улсыг
дарлан мөлжиж, хүч хөрөнгөө
аривтгаж байсан бүлгээ”. “Ёс байдал
иймийн шалтгаанаар ядран суусан
түмэн ард ба дарлагдаж хясагдсан
олон бага улсууд нь зовлонгийн туйл
дор хүрч энэхүү зовлон учруулсан уг
учир шалтгааныг илт мэдэж, тэдгээ-
рийг устгаж, ядрал зовлонгоос гэтэл-
сүгэй хэмээн ихэд хүчлэн оролдож
буй” (“Манай зорилго” өгүүлэл, 1971)
гэх буюу эсвэл “Шинээр тогтох
Монгол Улсын засгийн эрх мэдлийг
ард нийтээр эзлэн авч хууль журмыг
ард олны чөлөө эрх, ариун үнэн ба
тэгш сайныг баримтлан зохиож
ардын ба улсын хамаг хэрэг үйлсийг
өөрсдийн сонгосон үнэхээрийн итгэл-
тэй, эрдэмтэй шударга хүмүүсээр
бүтээлгэж байваас зохих нь цэлмэг
огторгуйд мандаж байх наран мэт ил
тодорхой болой” (Монгол Улсад ямар
засаг хэрэгтэй вэ).

“Манай мандах замыг таслахыг
хүсэгч

Мангас мэт харгис хятад
ээрхэгүүдийг

Илт мэсийн хүчээр эс хөөвөөс

Язгуур Монгол Улсын жаргах явдал

Хаврын цасан мэт хайлан хоцрох
биш үү” (Монгол Улс
сэрэмжилтүгэй)

Одоо Монгол Улс ба түүний
зориг хүслийг илтгэн удирдагч Ардын
нам болон уул ус юугаа энхрэн
өмгөөлөгч үнэнхүү монголчууд зэрэг
анги ялгаваргүй, шар хар бүгдээр
нэгдэн, санал зоригоо эрс чангад
илэрхий гарган тавьж, эрх засгаа
өөрсдийн гарт бат бэх барин авч,
үндсэн Монгол Улсын амгаланг
боловсрон мандах чөлөөт ахуй
байдлыг зохиох цаг тулж ирэв...

Манай Монголын ард түмэн,
түшмэд, ноёд, хутагт нар, хувилгаад,
хуваргууд, банди нар, хошууд ба
шавийн олон хар шар бүгдээр энэхэн
цагаар Богд гэгээний зөвшөөрөлт
сайшаасан Ардын намын дунд
нэгдэн хамтарч Монгол газар дээрээ
харгис Унгернийг илд мэсийн хүчээр
дийлэн арилгагтун”. (Монгол Улсын
энэ цагийн байдал ба ардын намын
бүтээх зүйлүүд тус)

“... Эдүгээ дэлхий дээр аливаа
үндэсний аймаг улс бүгд цөм өөр
өөрийн үндэс ёс суртлыг бадруулан
хүмүүжих эрхийг эрхлэн бүхий цаг
мөн тул тэнгэрийн заяа цагийн
улирлыг дагаж манай Монголын
газар бүрийн олон хошуу шавийн ард
түшмэд санал нэгдээд, чин үнэнхүү
зоригоор манай монгол үндэсний
олон амьтан уул газар ус юугаан
эзэлж, ... ардын зовлон жаргалын
живаа явдлыг бүгдээр зөвлөрөн
шийтгэж хүмүүжин боловсрох их
замыг нээж мөхсөн төр юүгээн дахин
шинэчлэн босгож тасарсныг залган,
хэмхэрснийг эвлүүлэн нийлүүлэх
үйлсэд амь бие эд зөөрөө огоортол
зүтгэсүгэй хэмээн бат журмаар
барилдан, Монгол Ардын Нам бай-

гуулж тус намын эрмэлзэх зүйлүүдийг манай монгол үндэсний түмэн ардад мэдэгдэн зарлах нь: (Монгол Ардын намаас гадаад монголын түмэнд тунхаглан зарлах)

“Эдүгээ байцааваас, Оросын хулгай Унгерн Хүрээ хотыг эзлэн Монголын засгийг дураар хөдөлгөөхөөс үл баран, Рибин улс тусалмуй хэмээх зэргийн зальт үг хуйхор аргаар мэхлэн, манай улсыг өөртөө эзэрхэх эрхтэй болгомуй хэмээн дэмий балай чалчиж, цөм өчүүхэн хүүхдийг хуурах мэт...

Ийм мэтийн илэрхий явдлыг эрхэм авгай нар эртхэн мэдэж хурц зэвсгийг нь эзлэн авч, хурдан хөөн гаргаж хойтын зовлонг арилгавал зохимуй.” (Монголын үнэн сонин, 1971)

Эдгээрийг уншаад эрхэм хүндэт уншигч танд юу бодогдож байна. Орос хүн бичиж үү, монгол хүн туурвиж уу? Үг, өгүүлбэрийн хэл хэллэг, бүтэц зохион байгуулалт, найруулга зүйгээс нь орос сэтгэлгээ үнэртэж байна уу, эсвэл монгол сэтгэхүй мэдрэгдэж байна уу? Ингэж би танаас асуухдаа тухайн цаг үед ОК/б/Н-ын болон Коминтерний зарим нөхөд бодлогоор өгүүлэл бичиж “Монголын үнэн” сонинд нийтлүүлж байсан байж болохыг ор тас үгүйсгэж буй хэрэг ердөө ч биш. Ийм тохиолдол гарч байсан байх бүрэн магадлалтай. Ажил үүргийнх нь хуваарьт ч албан ёсоор тусгагдаж байсан байж болно. Түүнийг нь харин “Монголын үнэн”-ээс гадна тухайн цаг үед хятад, солонгос, төвд зэрэг бусад хэл дээр хэвлэгдсэн сонин, сэтгүүлээс олж харьцуулан жишиж шинжилж үзвэл сонирхолтой үнэлэлт дүгнэлт гарна. Хэрэв тэдгээр хэл дээрх сонинуудын

нийтлэлийн ихэнх нь 1920-1921 онд зургаан дугаар гаргасан “Монголын үнэн” сонинтой яг адилхан, үгүйдээ гэхэд тавин хувь нь үг өгүүлбэр, цэг таслалгүй таарч нийлж байх юм бол сонирхолтой гаргалгаа гаргаж болох байх. Тийм баримтыг сөхөж тавьсан, харьцуулж баталгаажуулсан судлаачдын шинэ бүтээлтэй өчүүхэн бивээр хараахан танилцаж амжаагүй л явна. Тийм учраас ганцхан “Монголын үнэн” сониноор иш татаж байгаад энэ сонины үндсэн өгүүллүүдийг эхлээд орос хэлээр бичээд дараа нь монгол хэл рүү хөрвүүлсэн гэж таамаглах, батлах нь учир дутагдалтай, бүрэн гүйцэд гаргалгаа биш гэж бодном.

Их мэргэн Чингис хаан, Чингисийн мэргэн зарлиг гэх зэргээр Оросын коммунистууд, тухайн цаг үеийн Коминтернийхэн манайхныг тодотгож эзэн Чингис хаан, Хубилай сэцэний үед дэлхий дээр манай Монголын адил ижилгүй асар их хүчтэй, яруу суу алдартай өөр үндэстэн ястан байгаагүй гэж магтан бичих үү? Үгүй л болов уу.

“Цэлмэг огторгуйд мандан байх наран мэт”, “Хаврын цасан мэт хайлан хоцрох биш үү” гэх зэрэг адилтгал зүйрлэлээс нь яах ч аргагүй нүүдэлчин монголчуудын хэл ярианы соёлын цэцэн цэлмэг байдал илт мэдрэгдэж, “тэнгэрийн заяа цагийн улирлыг дагаж” хөдлөн тэмцэн босч “мөхсөн төр юүгээ дахин шинэчлэн босгож тасарсныг залган, хэмхэрснийг эвлүүлэх үйлсэд амь бие эд зөөрөө огоортол зүтгэсүгэй” гэх зэрэг аялгуу сайхан монгол хэл хэллэгээс нь монгол сэтгэлгээ, монгол омогшил нэвт шувт үнэртээд байгаа юм. Энэ бол “Монголын үнэн” сонины голлох

өгүүлэл, нийтлэлүүдийн зонхилох зохиогчид нь Монгол Ардын Нам, түүнийг үүсгэн байгуулагч зорилго, үйлс нэгт хувьсгалчдын бүтээл, манай бичиг соёлын дэвшилт сэхээтнүүдийн бичлэг байсан гэдгийг батлан харуулж буй баримт мөнөөсөө мөн. “Монголын үнэн” сонин 1921 оны ардын хувьсгалыг мандуулагчдын үндсэн зорилго, үйл ажиллагаа, стратеги тактикийн гол индэр, тэдний хүсэл тэмүүлэл, санал бодол, үнэнхүү чин эрмэлзлийн мөрийн хөтөлбөрийн хураангуйлсан цоморлиг болж байсныг дээрх баримтууд яруу тодоор харуулж байгаа юм.

Ийм индрийг буй болгоход нь, улмаар 1921 оны ардын хувьсгалаа ялалтад хүргэхэд нь харин ОК/б/Н, Коминтерний зүгээс санхүү-эдийн засаг, зэр зэвсэг, цэрэг техникийн харамгүй өгөөмөр тусламж үзүүлж хосгүй чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэдний эл тусламж дэмжлэггүйгээр уг хувьсгалыг харьцангуй богино хугацаанд бүрэн гүйцэд хэрэгжүүлэх боломж хомс байсан нь ойлгомжтой юм. Ингэж Монголд 1921 оны Ардын хувьсгалыг мандуулах Монгол Ардын Намын чин хүсэл эрмэлзэл нь ОК/б/Н, Коминтернээс тухайн цаг үед дэлхий дахинаа хувьсгалыг өрнүүлж өөрсдийн нөлөөг өргөжүүлэн тэлэх стратеги зорилго зорилттой яв цав нийцэж нийлсэн байна.

Үр дүнд нь “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” буюу 1920-1921 онд зургаан дугаар нь хэвлэгдсэн “Монголын үнэн” хэмээх сэтгүүл мэндэлжээ. “Монголын үнэн” сонин нь тусгаар тогтносон БНМАУ-ын түүхэн дэх хамгийн анхны намч марксист хэвлэл байв. “Монголын үнэн” сонин тус

улс дахь ангич, намч хэвлэлийн үндэс суурийг тавьж улмаар далаад жилийн турш үргэлжлүүлжээ, эдүгээ ч энэ зарчим дээрээ байгаа, тэгэхдээ ил тод байдал, олон ургальч үзэл санаагаар нийтлэлийн бодлогоо баяжуулж чөлөөт хэвлэлийн зүй тогтлыг түлхүү баримтлах болж өөрчлөгдөн шинэчлэгдсэн. Өөр нэг өвөрмөц содон онцлог, бусад сонин, сэтгүүлээс түүнийг онцгойруулан ялгаруулж буй зүйл гэвэл “Монголын үнэн” сонин нь тус улсын хэвлэлийн түүхэн дэх тасралтгүй 105 дахь жилдээ гарч буй цорын ганц сонин мөн билээ. Үүгээр түүний, өөрөөр хэлбэл “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” буюу “Монголын үнэн” сонины үнэ цэнэ, давтагдашгүй дайчин гэж хэлж болох түүхэн замнал нь тодорхойлогдоно.

Дүгнэлт. Дээр дурьдсан баримтууд, “Монголын үнэн” сонины анхны дугааруудын зарим нийтлэлд хийсэн задлан шинжлэлээс дараах үндсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

Нэг. 1920 оны 8 дугаар сард Оросод тусламж гуйхаар очсон Монгол Ардын Намын төлөөлөл-ардын хувьсгалчид Орос орон, тэдний хувьсгалчдын хувьсгалт үйл ажиллагааны туршлага, түүний дотор хувьсгалт тэмцлийг үзэл суртлын талаар хангах хэвлэлийн ажиллагааны туршлагыг идэвхтэй судалж, суралцахыг эрхэмлэн чухалчилж байжээ. Орос оронд тусламж гуйж очсон Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарын хувьсгалчид Эрхүү хотноо ОК/б/Н ба Коминтерний удирдагчид, тэрчлэн Чехийн нийтлэлч Ярослав Гашек нарын зэрэг хувьсгалчидтай уулзаж хэвлэх үйлдвэр, хэвлэлийн

үйл ажиллагааны туршлага судалж санал солилцож байсан нь түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн холбогдох баримтуудаар батлагдаж байна.

Хоёр. Айлын талд Ардын Намын төлөөлөгчдөөс албан ёсоор хүсэлт болгож тавьсан “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” нь практикт “Монголын үнэн” сониноор, тэрчлэн 1921 оны ардын хувьсгалчдын нууц ухуулах хуудас, уриалга зэргээр биеллээ олжээ.

Гурав. 1920-1921 онд хилийн чанадад зургаан дугаарыг хэвлэн гаргаж, нууцаар Монголд оруулж ирж тараасан “Монголын үнэн” сонины үндсэн гол нийтлэлүүдэд утга агуулгын болоод бичлэгийн дүр дүрслэл, найруулга зүй, монгол хэл шинжлэлийн үүднээс задлан шинжлэл хийж үзэхэд эдгээр бичлэг нь гаднын хэн нэгний гараар эхлээд орос хэл дээр шууд бичигдэж тухайлбал ОК/б/Н ба Коминтерний эрх ашиг, албан ёсны байр суурийг хамгаалж өөрсдийн санаа бодлоо монголчуудад шууд тулган хүлээлгэх гэсэн өнгө аяс төдийлөн мэдрэгдэхгүй байна. Харин Монгол Ардын Нам, 1921 оны ардын хувьсгалчдын амин эрх ашиг, тэмцлийн стратеги тактик хийгээд зорилго зорилтыг илүүтэй тод томруунаар илэрхийлж, үндсэн гол нийтлэл бүрээс нь монгол омогшил оргилж бадарч, монгол сэтгэлгээ, монгол сэтгэхүй нэвт шувт үнэртэж мэдрэгдэж байгаа нь тодоор харагдаж байгаа юм. Энэ бол “Монголын үнэн” сонины голлох нийтлэлүүдийн зохиогчид нь монголчууд өөрсдөө байсны тод нотолгоо юм.

Зэрэг анги ялгаварлалгүйгээр ард түмэн, түшмэд, ноёд, хутагт нар, хувилгаад, хуваргууд, банди нар

/лам/, хошууд ба шавийн олон бүгдээрээ Богд эзний зөвшөөрч сайшаасан Ардын намаа тойрон нэгдэж Монгол газраас харгис Унгернийг илд мэсийн хүчээр дайлан арилгая. Мөхсөн төр юүгээ дахин шиэчлэн босгож тасарсныг залган, хэмхэрснийг эвлүүлэн нийлүүлэх үйлсэд амь бие эд зөөрөө огоортол зүтгэцгээе гэж “Монголын үнэн” сонин уриалж байжээ.

Дөрөв. 1920 оны 11 дүгээр сарын 10-нд эхнийх нь дугаар хэвлэгдсэн “Монголын үнэн” сонины анхны эрхлэгчийг Сономбалжирын Буяннэмэх гэж үзэх нь түүхэн үнэнд илүүтэй нийцэхээр байна. 1920-1921 онд зургаан дугаар гаргасан “Монголын үнэн” бол Монголд үүсч буй болсон намч, марксист хэвлэл мөн бөгөөд тасралтгүй үргэлжлэн 105 дахь жилдээ гарч байгаа цорын ганц сонин юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Урианхан Галаарид.Б “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021
2. Даш.Д Монголын үнэн сонин /Сонинд нийтлэгдсэн өгүүлэл мэдээний эмхэтгэл/. УБ. 1971
3. Дүйнхэржав.Г Сономбалжирын Буяннэмэхийн улс төрийн намтар. УБ. 1997
4. Дэлэг.Г Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. 1971
5. Монголын үнэн /1920-1921 онд хэвлэгдсэн зургаан дугаарын эмхэтгэл/ УБ. 2023
6. Үнэн сонин ба чөлөөт сэтгэлгээ /Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, эмхэтгэсэн Г.Сонинбаяр/ УБ. 2020
7. Үнэн: Наян жилийн намтрын товъёог /1920-1996/. Товъёог үйлдсэн доктор Лодонгийн Түдэв. УБ. 2000

8. “Үнэн” 2000. 84 дэх жилдээ /Эрхэлсэн Хорлоогийн Цэвлээ/ УБ. 2004
9. Баасансүрэн.Т Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь цувралын “1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил” /дэд дэвтэр/ УБ. 2009
10. Баасансүрэн.Т Сономбалжирын Буяаннэмэхийн уран бүтээл,

бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ. УБ.2019

Keywords: People's Party members, "Mongoliin unen" newspaper, content, method, and imagery of the recording, party Marxist publications, secret leaflets.